



СЭЛЭНГЭ АЙМАГ  
ЦАГААННУУР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 49

Хуурч

Төсөл сонгон шалгаруулах хороо  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2021 оны А/361 дугаар тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.3.2, 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл сонгон шалгаруулах хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай

Хорооны дарга: Д.Алтанзориг (ЗДТГ-ын дарга)

Нарийн бичгийн дарга: Ч.Хонгорзул (Хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:Х.Дашцэрмаа (Санхүү албаны дарга)

Э.Саранчимэг (Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга)

Б.Буянт (“Хуурч сүрэг” хоршооны дарга)

2.Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгийг журмын дагуу чиглэлийн хүрээнд сонгон шалгаруулалт хийж зохион байгуулж ажиллахыг Хорооны дарга /Д.Алтанзориг/-д даалгасугай.

3.Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл авах, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам” шинэчлэгдсэнтэй холбогдуулан олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахыг Хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн /Ч.Хонгорзул/-д даалгасугай.

4.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 30 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Г.ЦЭНДСҮРЭН

